

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ИЛ ТОД БАЙДЛЫН 2019 ОНЫ МЭДЭЭ, ТАЙЛАН
/2019 оны хагас жилийн байдлаар/

/2019-06-20/

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
Нэг.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал		
1	<p>Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулсан тухай бүр шинэчлэх</p>	<p>1/“Монгол Улсын эмгэг судлалын шинжлэх ухааныг тэргүүлэгч байхад оршино.” гэсэн эрхэм зорилго, зорилтыг тэргүүлэх чиглэл болгон. Олон Улсын Стандартчиллын “MNS ISO 15189:2015”-ыг хэрэгжүүлэгч байгууллага болохоор зорилт тавьж, хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>-Энэхүү зорилго, зорилт, зохион байгуулалтын бүтцийг өөрийн байгууллагын мэдээллийн самбар болон цахим хаяг/www.emgegsudlal.mn/-ийн нүүр, иргэд, үйлчлүүлэгч нарт харагдахуйц хэсэгт тус тус байршуулсан.</p> <p>2/ 2019 онд Эмгэг судлалын үндэсний төв нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан төлөвлөгөөнд туссан арга хэмжээ болох “... эмгэг судлалын тусламж, үйлчилгээг үндэсний хэмжээнд бэхжүүлэх, хүний нөөцийг нэгдүүлэх ...” үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, энэ тухай мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт байгууллагын цахим хаягт мэдээлж байна.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Стандартын хэрэгжилтийн талаар судалгаа авч, хэрэгжилтэд үнэлгээ хийх, зөвлөмж гаргах ажлыг хэрэгжүүлэхээр 21 аймгийн нэгдсэн эмнэлгийн стандартын хэрэгжилтийн талаар 2019.05.21-ны өдрийн 152 тоот албан бичгээр судалгаа авахаар хүргүүлсэн. - Төлөвлөгөөний дагуу 2019 онд нэр бүхий 11 стандартын төсөл боловсруулсан. -2019 онд Хөвсгөл, Говь-Алтай, Өвөрхангай, Сүхбаатар, Дорнод, Төв, Хэнтий, Өмнөговь, Дундговь аймаг, Нийслэлийн Бага-нуур, Налайх, Төмөр замын нэгдсэн эмнэлэгт тушаалын хэрэгжилттэй холбоотойгоор үнэлгээ хийх, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг газар дээр нь очиж шалгаж, шалгалтын дүнг танилцуулж, ажилласан. -2019 онд ЭМС-ын 2017 оны “Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2017-2020 оны тэргүүлэх чиглэл батлах тухай” А/312 дугаар тушаалын дагуу 2019 оны 3-р улиралд дараах чиглэлүүдээр Солонгосын АСАН эмнэлэгт 3-4 эмнэлгийн мэргэжилтэнг дараах мэргэжлийн чиглэлээр сургахаар бэлтгэл ажил хийгдэж байна. <p style="text-align: center;">-Хүүхдийн эмгэг судлал; -Молекул патологи;</p> <p>-2019 оны 05 сард үе шаттайгаар 21 аймгийн нэгдсэн эмнэлгийн эмгэг судлалын эд, эсийн лабораторийн 20 техникч нар “... Ажлын байрны мэргэжил дээшлүүлэх давтан</p>

		<p>сургах ...“ сэдэв бүхий чадавхжуулах сургалтанд бүрэн хамрагдсан. Хэрэгжилт:90 хувь</p> <p>-2019 онд энэ оны 3-р сараас “Эд, эсийн лабораторийн лаборант”-ийн төрөлжсөн мэргэшил олгох сургалтанд Дархан-Уул аймаг, Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэгийн хэрэгцээ, захиалгаар тус бүр 1, нийт 2 лабораторийн техникч нарыг сургаж, бэлтгэж байна.</p> <p>-2018, 2019 онд зайн оношилгооны тоног төхөөрөмжийг ашиглан 18 тохиолдолд оффлайн зөвлөгөө авч, аймаг орон нутагт 10 тохиолдолд зөвлөгөө өгсөн.</p> <p>-2019 онд байгууллагадаа стандартыг хэрэгжүүлэхтай холбоотойгоор ЭСҮТ-өөс 36 журам, шинжилгээний САЗ 6-г, тоног төхөөрөмжийн САЗ 17-г, заавар 5-г, бүртгэл 70-г хийж боловсруулж, баталж, 15 удаагийн сургалт, 1-сарын аян зарлах зэрэг ажлуудыг зохион байгуулсан.</p> <p>-2019 онд ЭСҮТ-ийн захирлын 2019 оны А/18 дугаар тушаалаар баталсан удирдамж, дэмжлэгт үнэлгээний баг, бүрэлдэхүүн 2019 оны 04, 05 дугаар сард батлагдсан хуваарийн дагуу ХӨСҮТ, УНТЭ-ийн эмгэг эд, эс судлалын лабораторийн үйл ажиллагаатай танилцаж, эмгэг судлалын тусламж үйлчилгээний дэмжлэгт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна.</p> <p>-2019 онд энэхүү лабораторийн үйл ажиллагаа, эд, эсийн шинжилгээг хэрхэн хийж байгаа чанарын үнэлгээнд 2019 оны 06 дугаар сард туршилтын хяналтад хамрагдахаар бэлтгэл ажлыг хангаж, Conventional Gynaecological Module, Technical General Module, General Diagnostic Module хөтөлбөрүүдэд хамрагдаж байна.</p> <p>-2019 онд энэхүү эмгэг судлалын тусламж, үйлчилгээтэй холбоотой тохиолдол, мэргэжил арга зүйгээр хангах ажлын хүрээнд теле уулзалт, хурал, сургалтыг давхардсан тоогоор 23 удаа хийж, хэлэлцсэн 4 тохиолдолд хамтарсан хурлыг зохион байгуулж, тогтмолжуулан ажиллаж байна.</p> <p>-2019 онд Япон улсын Мита эмнэлэг, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын олон улсын их сургуулийн Патологийн тэнхимийн профессор, телепатологич Ичиро Моритой хамтран ажиллаж, зайн оношлогооны тоног төхөөрөмжөөр 23 тохиолдолд зөвлөгөө авч, иргэдийн өвчин, эмгэгт онош, дүгнэлт гаргах, баталгаажуулах ажлыг хийсэн.</p> <p>-2019 онд орон нутгийн Дорнод, Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгийн эмгэг судлаач, эс судлаач эмч нарыг оролцуулсан 2 удаагийн теле-уулзалт, нэг удаагийн эмнэлзүй эмгэг судлалын теле-хурал, 4 тохиолдолд зөвлөгөө өгсөн.</p> <p>-2019 онд Оношлуурын тоо, тоног төхөөрөмжийг 20%-иар нэмэгдүүлэх чиглэлээр Иммуногистохимийн шинжилгээ, лабораторийн үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр 2019 оны эхний 5 сарын байдлаар 144 хүний 348 блок шинжилгээнд хавдрын ба хавдрын бус ялган оношилгоог хийж, оношлуурын нийлүүлэлтийг 39 нэр төрлийн эсрэгтөрөгчийг нэмэгдүүлэн, тогтмол ашиглаж байна. Энэхүү эсийн блокийн тусламжтайгаар иммуноцитохимийн аргаар хавдрын эсийн гарвалыг тодорхойлж, 39 төрлийн иммуногистохимийн эсрэг бие/антибоди/ ашиглан онош, дүгнэлт өгсөн.</p>
2	<p>Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах</p>	<p>-Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй, шуурхай, хариуцлагатай, ёс зүйтэй байдлыг хангахаар зорилгоор Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын “Журам, хуваарь батлах тухай” 2016 оны А-53 дугаар тушаалаар төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн ажиллах журмыг шинэчлэн баталсан.</p>

	цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх,	1/2019 онд энэхүү мэдээллийг иргэдэд харагдахуйц, ойлгомжтой хэлбэрээр үйлчлүүлэгчдийн нүдэнд ил харагдах газар мэдээллийн самбарт өргөдөл гомдол, албан бичиг, санал хүсэлтийг хүлээн авах ажилтан, өрөө, холбогдох утасны мэдээлэл, санал, хүсэлтийн хайрцаг тус тус шинэчлэн байршуулсан. -Иргэдийг хүлээн авч уузлах цагийн хуваарийг нээлттэй ил тод байдлаар байршуулан, төвийн захирал, тасгийн эрхлэгч, албадын дарга нарын иргэдтэй уулзах хуваарийг, мөн иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хяналт тавьж ажиллах ажилтны асуудлыг зохицуулсан. Хуваарийг http:// patho-logy-center.gov.mn/ цахим хуудас болон мэдээллийн самбарт тус тус шинэчлэн байршуулсан.
3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Эмгэг судлалын үндэсний төвийн лавлагаа, лабораториор үйлчлүүлж байгаа иргэд, үйлчлүүлэгч нарт тусламж, үйлчилгээ авахад шаардлагатай баримт бичиг, эд, эсийн шинжилгээ өгөх үед тавигдах шаардлага, төлбөрт үйлчилгээний үнийн тариф зэрэг мэдээллийг байгууллагынхаа цахим хуудас/ www.pathology-center.gov.mn/ , иргэдэд харгадахуйц газар буюу мэдээллийн самбарт ойлгомжтой хэлбэрээр шинээр байршуулсан.
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	-Эрүүл мэндийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан үндсэн үйл ажиллагаа явуулахтай холбоотой Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан 2017 оны А/07, А/55 дугаар тушаалаар баталсан журмууд болон төвийн үйл ажиллагаатай холбоотой зохион байгуулалтын шинжтэй нийт 26 журмыг байгууллагын цахим хуудас/ www.pathology-center.gov.mn/ эрх зүйн цэс болон мэдээллийн самбарт ил тод, нээлттэй байдлаар байршуулсан.
5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсанд 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөл тусгах,	-Эрүүл мэндийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасан эмгэг судлалын тусламж, үйлчилгээтэй холбоотой нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр, журмыг Эмгэг судлалын үндэсний төв дангаар боловсруулан, байгууллагын сайт болон Эрүүл мэндийн яамны сайтад ил тод нээлттэй байдлаар байршуулан, бусад эрүүл мэндийн байгууллагуудаас нийт давхардсан тоогоор 43 санал ирүүлсэн. Үүнээс 12 саналыг журмын төсөлд тусган. Нөлөөллийн шинжилгээ хийж, Эрүүл мэндийн байгууллага, Төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан, хэлэлцүүлэг хийн. Эрүүл мэндийн сайдын “Эмгэг судлалын шинжилгээ хийх журмыг шинэчлэх батлах тухай” 2017.02.02-ны өдрийн А/55 дугаар тушаалын хавсралтаар баталж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2017.02.10-ны 3697 улсын бүртгэлд бүртгүүлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. -Мөн “Амьд сорьц, эмгэг эс судлалын шинжилгээ хийх журмыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2017.01.06-ны өдрийн А/07 дугаар тушаалын дагуу үйл ажиллагаанд мөрдөж байна. Энэхүү журмуудыг боловсруулахад иргэд болон мэргэжлийн салбар зөвлөл, эрүүл мэндийн салбарын эрдэмтэн, мэргэжилтнүүдээс санал авч, тусгаж байсан болно.
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх,	1/ 2019 онд Эмгэг Судлалын Үндэсний Төвөөс 2019 оны “Эмгэг судлалын тусалжм, үйлчилгээний чанар хүртээмж, менежментийг сайжруулах” жил болгосон. /төвийн захирлын 2019.03.12-ны өдрийн А/14 дугаар тушаал/. Энэхүү ажлын хүрээнд Чанарын алба нь төлөвлөгөөт болон цаг үеийн хяналт шалгалт хийх, байгууллагын ISO:9001,

		<p>лавлагаа, лабораторийг 15189:2015 стандартыг хэрэгжүүлэгч байх, магдлан итгэмжлэлд тус тус бэлтгэж, холбогдох дотоод зохион байгуулалтын шинжтэй журмаа шинэчлэх, бусад бэлтгэл ажлыг хийж, хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2/ Мөн 2019 онд энэхүү лабораторийн үйл ажиллагаа, эд, эсийн шинжилгээг хэрхэн хийж байгаа чанарын үнэлгээнд 2019 оны 06 дугаар сард туршилтын хяналтад хамрагдахаар бэлтгэл ажлыг хангаж, Conventional Gynaecological Module, Technical General Module, General Diagnostic Module хөтөлбөрүүдэд хамрагдаж байна.</p> <p>3/ 2019 онд мөн эмгэг судлалын үндсэн үйл ажиллагаа явуулж буй эмч нарын үйл ажиллагаатай холбоотойгоор ЭСҮТ захирлын “Сахилга хариуцлага, тусламж, үйлчилгээний үйл ажиллагааны үр дээшлүүлэх, сайжруулах талаар 2019.06.07-ны өдрийн А/47 дугаар тушаалаар үүрэг, даалгавар, чиглэл өгч, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж байна.</p>
7	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх	Эмгэг судлалын үндэсний төвийн үйл ажиллагаатай холбоотойгоор төрийн бус байгууллагаар ажил, тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлж байгаа тохиолдол байхгүй болно. Тиймээс энэхүү мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах мэдээлэл байхгүй.
8	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх,	Төв нь хууль тогтоомж болон бусад дүрэм, журамд заасны дагуу эмгэг судлалын тусламж, үйлчилгээ үзүүлдэг тул тодорхой чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгодоггүй болно. Тиймээс энэхүү мэдээллийг цахим хуудаст байршуулах мэдээлэл байхгүй.
9	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх,	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр арга хэмжээ байхгүй болно. Тиймээс энэхүү мэдээллийг цахим хуудаст байршуулах мэдээлэл байхгүй.

ТАНИЛЦСАН: ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Г.УЯНГА

ТАЙЛАН ГАРГАСАН: БТА-НЫ ДАРГА

С.БАТБААТАР